

МӨНГӨН ТЭМДЭГТИЙГ ТУСГАЙ ЗОРИУЛАЛТААР ХУДАЛДАХ, ХУДАЛДАН АВАХ ТУХАЙ ЖУРАМ

НЭГ. Нийтлэг үндэслэл

1.1 Энэхүү журмын зорилго нь Монголбанкны нөөцөд байгаа Монгол Улсад 1993 оноос өмнө гүйлгээнд байсан (гүйлгээнээс хасагдсан) мөнгөн тэмдэгт болох цаасан дэвсгэрт, тэдгээрийн загвар (цаашид “мөнгөн тэмдэгт” гэх) болон дурсгалын зориулалтаар үйлдвэрлэсэн цаасан дэвсгэрт (цаашид “зүсэгдээгүй мөнгөн тэмдэгт” гэх)-ийг иргэн, хуулийн этгээд (цаашид “сонирхогч этгээд” гэх)-д худалдах, тэдгээрээс худалдан авахтай холбоотой үйл ажиллагааг зохицуулахад оршино.

1.2 Энэ журамд дараах нэр томъёог дор дурдсан утгаар хэрэглэнэ:

1.2.1 “мөнгөн тэмдэгт” гэж Монголбанкны нөөцөд байгаа Монгол Улсад 1993 оноос өмнө гүйлгээнд байсан цаасан дэвсгэрт, зоосыг;

1.2.2 “зүсэгдээгүй мөнгөн тэмдэгт” гэж Монгол Улсад гүйлгээнд байгаа мөнгөн тэмдэгтийн цаасан дэвсгэртийн хэлбэрийн зүсч гүйлгээнд гаргахад бэлэн болгоогүй, дурсгалын буюу сонирхогч этгээдэд худалдах зорилгоор үйлдвэрлэсэн цаасан дэвсгэртийг.

1.3 Энэхүү журмыг Монголбанкны Мөнгөн тэмдэгт, үнэт зүйлсийн газар (цаашид МТҮЗГ гэх), болон Төлбөр тооцоо, бүртгэлийн газар (цаашид ТТБГ гэх) үйл ажиллагаандаа дагаж мөрдөнө.

ХОЁР. Мөнгөн тэмдэгтийн нөөцийг ангилах

2.1 Монгол Улсад 1993 оноос өмнө гүйлгээнд байсан мөнгөн тэмдэгтийн нөөцийг ангилахдаа дараах үндсэн хоёр хэсэгт хуваана:

2.1.1 Худалдах дээд хязгаарт хүрсэн гүйлгээнээс татагдсан, зүсэгдээгүй болон загварын мөнгөн дэвсгэрт: Үүнд тухайн гүйлгээнээс татагдсан мөнгөн тэмдэгтийн заавал байлгах нөөцийн хэмжээ нь ширхэгээр 5000 /таван мянга/ ба түүнээс бага, шинээр хэвлэгдсэн зүсэгдээгүй мөнгөн тэмдэгтийн заавал байлгах нөөцийн хэмжээ тус бүр нь ширхэгээр 100 /нэг зуу/ ба түүнээс бага тоотой байгаа мөнгөн тэмдэгт хамаарна.

2.1.2 Хязгаарлагдмал хүрээнд худалдах гүйлгээнээс татагдсан, зүсэгдээгүй болон загварын мөнгөн дэвсгэрт: Үүнд тухайн гүйлгээнээс татагдсан мөнгөн тэмдэгтийн заавал байлгах нөөцийн хэмжээ нь ширхэгээр 5001/таван мянга нэг/-ээс дээш тоотой, зүсэгдээгүй мөнгөн тэмдэгтийн заавал байлгах нөөцийн хэмжээ нь ширхэгээр 101 /нэг зуун нэг/-ээс дээш тоотой мөнгөн тэмдэгт хамаарна.

2.2. Гүйлгээнээс татагдсан мөнгөн тэмдэгтийн нөөцийг нэмэгдүүлэх: Монголбанкны нөөцөд байхгүй эсвэл нөөцийн тоо 1000 ширхэгээс доош Монгол Улсын 1993 оноос өмнө гүйлгээнд байсан мөнгөн тэмдэгтийг сонирхогч этгээдээс худалдан авч болно.

ГУРАВ. Мөнгөн тэмдэгтийг худалдах, худалдан авах тоо хэмжээ, үнэ тогтоох

3.1. Энэ журмын 2.2.-т заасан мөнгөн тэмдэгтийг худалдан авах, 2.1.2-т заасан мөнгөн тэмдэгтийг худалдах мөнгөн тэмдэгтийн хэмжээг тогтоож, үнийн саналыг Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар томилогдсон “Мөнгөн тэмдэгт худалдах, худалдан авах ажлын хэсэг”/цаашид Ажлын хэсэг гэх/ зах зээлийн үнэ болон 3.2 дахь заалтыг үндэслэн тогтооно.

3.2. Ажлын хэсэг энэ журмын 2.1.2-т заасан худалдах зүсэгдээгүй мөнгөн тэмдэгтийн 20000, 10000, 5000-тын цаасан дэвсгэртийг номинал нэрлэсэн үнээс 1,5-2 дахин; 1000, 500-тын цаасан дэвсгэртийг номинал нэрлэсэн үнээс 5-10 дахин; 100-тын цаасан дэвсгэртийг номинал нэрлэсэн үнээс 20-40 дахин; 50, 20, 10, 5,1-тийн цаасан дэвсгэртийг номинал нэрлэсэн үнээс 30-50 дахин тус тус нэмэгдүүлэн тооцно.

3.3. Монголбанкны Ерөнхийлөгч энэ журмын 3.1, 3.2.-т заасан заалтыг үндэслэн шийдвэр гаргана.

ДӨРӨВ: Мөнгөн тэмдэгтийг худалдах

4.1. Энэ журамд заасан мөнгөн тэмдэгтийг худалдах үйл ажиллагааг Монголбанкны Ерөнхийлөгчийн шийдвэрийн дагуу МТҮЗГ-аас эрхлэн зохион байгуулна.

4.2. Монголбанкны ажилтан болон бусад сонирхогч этгээдэд тухайн оны мөнгөн тэмдэгтийн нэг иж бүрдлээс илүүгүйг худалдана.

4.3. МТҮЗГ хянаж зөвшөөрсөн захиалагчийн хүсэлт, өргөдлийн дагуу сонирхогч этгээдээс төлбөрийг хүлээн авч, тушаасан баримтыг үндэслэн мөнгөн тэмдэгтийг олгоно.

4.4. Мөнгөн тэмдэгтийн эх загварыг худалдахыг хориглоно.

ТАВ: Мөнгөн тэмдэгтийг худалдан авах, солилцох

5.1. Энэ журмын 2.2.-т заасан тухайн жилд худалдан авах мөнгөн тэмдэгтийг худалдан авах ажиллагааг МТҮЗГ-ын Мөнгөн тэмдэгтийн хэлтэс эрхлэн гүйцэтгэнэ. Үүнийг ТТБГ Монголбанкны нягтлан бодох бүртгэлийн журмын дагуу худалдан авсан мөнгөн дэвсгэртийг бүртгэж авна.

5.2. Ховордсон мөнгөн тэмдэгтийн үлдэгдлийг нөхөх зорилгоор тухайн жилд худалдан авах мөнгөн тэмдэгтийн нийт хэмжээнд тооцон Монголбанкны Ерөнхийлөгчийн зөвшөөрөлтэйгээр бусад этгээдтэй солилцвол ТТБГ энэ журмын 5.1-д заасан журмын дагуу солилцсон мөнгөн дэвсгэртийн бүртгэл хөтөлнө.

5.3. Худалдан борлуулсан, худалдан авсан, солилцсон мөнгөн тэмдэгтийн тайланг хавсралтын дагуу гаргаж тухай бүр МТҮЗГ-ын захиралд, хагас жил тутам Тэргүүн дэд ерөнхийлөгчид танилцуулна.

ЗУРГАА. Мөнгөн тэмдэгтийг хадгалах

6.1. Монгол Улсад 1993 оноос өмнө гүйлгээнд байсан цаасан дэвсгэрт, зоос түүний дотор бусдаас худалдан авсан мөнгөн тэмдэгтийг зориулалтын тусгай сейф, хамгаалалтын сав, хайрцагт хадгална.

6.2. Мөнгөн тэмдэгтийг цаасан дэвсгэрт, зоос тус бүрээр тусгаарлаж хадгална.

ДОЛОО. Хяналт, хариуцлага

8.1. Мөнгөн тэмдэгт худалдах, худалдан авах үйл ажиллагаанд МТҮЗГ байнгын хяналт тавина.

8.2. Энэ журмыг зөрчсөн этгээдэд тухайн зөрчлийн шинж байдал нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол Монголбанкны Хөдөлмөрийн дотоод журмын дагуу хариуцлага хүлээлгэнэ.